



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/012/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2026 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Аудитор: У.Батчимэг

Утас: 88094175

Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1.Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/.....	11
4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/.....	11
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2025.03.25 № 269
танай _____-ны № _____-т

ХОВД СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.СЕРИКБОЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд аймгийн Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ховд сум нь тайлант онд 3937 хүн амтай, жилийн эцсийн мал тооллогоор 218,759 толгой мал тоолуулжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ховд сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 732,920.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогыг 109,140.0 мянган төгрөгөөр буюу 117 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилтын хүрээнд 101 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, дэвшүүлсэн зорилт гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 91.1 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	603,384.92	720,736.16
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	330,416.32	386,479.97
3	1.1.3 АВЛАГА	145,187.87	192,628.48
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	39,096.8	22,420
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	88,683.93	119,207.71
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,830,599.95	3,891,592.96
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,830,599.95	3,891,592.96
8	1.2.2.02 Биет хөрөнгө	3,793,189.7	3,854,407.71
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	37,410.25	37,185.25
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,433,984.87	4,612,329.13
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,960	38,999.25
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,960	38,999.25
13	2.1.1.03 Өглөг	1,960	38,999.25
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,432,024.87	4,573,329.87
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	4,432,024.87	4,573,329.87
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	316,625.5	316,625.5
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	3,985,775.17	4,127,080.18
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	129,624.2	129,624.2
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	4,433,984.87	4,612,329.13

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,793,070.2	2,796,106.76
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	719,627.55	719,342.09
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	566,915.81	545,284.17
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	576,971.74	563,186.03
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-10,055.93	-17,901.86
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	17,043.34	25,319.02
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	135,668.4	148,738.91
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	554,946.74	2,076,764.66
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,252,436.34
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,518,495.91	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,444,620.51	2,654,801.76
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,444,620.51	2,654,801.76
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,392,321.58	2,606,628.35
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	779,753.47	932,156.67
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,103.82	118,558.6
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	600,834.08	617,956.68
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	506,350.11	492,550.33
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	553.7	140.3
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	8,471.7	16,290.3
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	7,438.5	11,487
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,711.03	45,713.76
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	329,105.16	371,774.7
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,298.94	48,173.41
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	348,449.68	141,305
25	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	348,449.68	141,305

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,317,386.77	2,428,903.8
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	719,627.55	719,342.09
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	566,915.81	545,284.17
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-10,055.93	-17,901.86
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	17,043.34	25,319.02
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	135,668.4	148,738.91
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	30,183.08	29,742.87
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	31,715.05	31,505.48
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	73,770.27	87,490.57
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,263.32	1,709,561.71
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	79,263.32	91,719.46
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,254,511.65
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	363,330.6
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,518,495.91	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,684,631.05	1,839,310.84
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,684,631.05	1,839,310.84
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,632,332.11	1,791,293.43
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	778,215.75	932,156.67
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,641.55	118,558.6
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	600,834.08	617,956.68
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	39,146.01	29,792.9
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	553.7	140.3
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	13,377.4	12,869.3
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	7,438.5	8,096.3
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,925.53	34,568.36
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	45,199.6	37,154.31
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,298.94	48,017.41
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	632,755.72	589,592.96
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	493,162.4	445,529.31
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	493,162.4	445,529.31
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	493,162.4	445,529.31
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-493,162.4	-445,529.31
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	30,000	88,000

34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-30,000	-88,000
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	109,593.32	56,063.65
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	220,823	330,416.32
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	330,416.32	386,479.97

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,083,575.19	4,083,575.19
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,083,575.19	4,083,575.19
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	348,449.68	348,449.68
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,432,024.87	4,432,024.87
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,432,024.87	4,432,024.87
6	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,432,024.87	4,432,024.87
7	1.7 Тайлант үеийн үр дүн	141,305	141,305
8	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,573,329.87	4,573,329.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,331,630.40	2,406,443.60
11	3.1.01.1.1 Татварын орлого	618,175.10	719,342.00
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	470,851.10	545,284.10
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	488,753.00	563,186.00
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(17,901.90)	(17,901.80)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	33,400.00	25,319.00
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	113,924.00	148,738.90
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	23,090.00	29,742.80
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	17,474.00	31,505.40
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	73,360.00	87,490.50
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,713,455.30	1,687,101.60
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,244,519.60	1,244,516.60
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	363,330.70	363,330.60
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,499,378.60	2,353,946.60
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,838,499.60	1,820,420.50
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,836,466.00	1,772,403.10
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	948,469.60	932,156.60

Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,558.60	118,558.60
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	636,977.70	618,055.50
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	19,267.10	16,712.10
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.20	140.30
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	13,331.10	12,869.30
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	9,211.60	8,096.30
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,801.40	32,925.90
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	39,165.70	32,888.50
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,033.60	48,017.40
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,213.00
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	2,033.60	1,213.00
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	560,879.00	445,529.20
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.00	88,000.00
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		(52,497.00)
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		52,497.00
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(167,748.20)	(52,497.00)
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	328,341.00
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	380,838.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	2025.12.31
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,992.05
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,992.05
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	9,992.05
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	9,992.05
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	9,992.05
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,720.0
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,235.3
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,036.7
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,387.34
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	4,387.34
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,387.34
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	652.9
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	652.9
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,642.3
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,642.3
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	2,092.0
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	2,092.0

4	1.1.1	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	5,604.7
---	-------	-----------------------------------	----------------

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 73,140.1 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил² илэрснээс аудитын явцад 43,528.3 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн-47,486.3 мянган төгрөг;
- Мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй – 95,0 мянган төгрөг

Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- Санхүү байдлын тайланд урьдчилж гарсан зардал 12,376.8 мянган төгрөг зөрүүтэй илэрхийлсэн
- Санхүүгийн байдлын тайланг зөрүүтэй тайлагнасан– 13,182.0 мянган төгрөг,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 39,560.5 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар 3 зөрчилд зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.Зөвлөмж

3.1.1 Орон нутаг хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-д гэрээг байгуулан урьдчилгаа төлбөр олгосон, гэрээний хувийг харилцан адилгүй хувиар байгуулан ажиллаж байгаа зөрчлүүд илэрлээ. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; ” 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно” гэсэн заалтуудтай нийцээгүй нь санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

3.1.2 Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний ажлуудад хөтөлбөр боловсруулан батлаагүй, хөтөлбөрийн хүрэх түвшинг боловсруулан ажиллаагүй зөрчлүүд байна. Энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ гэсэн журмын хэрэгжилтийг ханган ажиллах” гэж заасантай нийцээгүй нь, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ажлуудын гэрээний хэрэгжилт үр дүнг тооцож ажиллах,

3.1.3 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийг 2 аж ахуй нэгжид 88.0 сая төгрөгий зээлийг олгохдоо хоршооны гишүүдийн хурлын тэмдэглэл, протокол, хоршооны хуулийн этгээдийн лавлагаа, хамтран зээлдэгчийн мэдээлэл дутуу, мөн зээлийн гэрээ алдаатай бичсэн зэрэг зөрчил байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-н холбогдох заалтуудтай нийцээгүй байгаа нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хоршооны гишүүдийн хурлын тэмдэглэл, протукал, хоршооны хуулийн этгээдийн лавлагаа, хамтран зээлдэгчийн мэдээлэл, мөн зээлийн гэрээ алдаатай бичсэн зэрэг зөрчлүүдийг зарлуулан ажиллаж А/361 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хоршоо хөгжүүлэх сан	Олгосон зээлийг зөрүүтэй бүртгэсэн	1	95.00			1	95.00	1	95.00				
Хоршоо хөгжүүлэх сан	Үр дүнгийн тайланд үр дүнг зөрүүтэй тайлагнасан	1	47,486.3			1	47,486.3	1	47,486.3				
Орон нутгийн хөгжлийн сан	Санхүүгийн байдлын тайланд байгууллагад төлөх өглөг зөрүүтэй тайлагнасан	1	13,182.0			1	13,182.0	1	13,182.0				
Орон нутгийн хөгжлийн сан	Санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардал зөрүүтэй тайлагнасан	1	12,376.80			1	12,376.80	1	12,376.80				
ДҮН		4	73140.1	0	0	4	73140.1	4	73140.1				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

[Type here]

Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Орон нутгийн хөгжлийн сан	ОНХС-аар хэрэгжүүлж байгаа ТАХ-д гэрээг байгуулан урьдчилгаа төлбөр олгож байна мөн гэрээний санхүүжилтийн хувийг харилцан адилгүй хувиар байгуулсан ажиллаж байна.	1						1		
	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ажлуудын гэрээний хэрэгжилт үр дүнг тооцож, хөтөлбөр боловсруулан батлан ажиллах, хүрэх түвшин хүрсэн түвшинг тухай бүрт хэлэлцэн ажиллаагүй	1						1		
ХХСан	Хоршооны гишүүдийн хурлын тэмдэглэл, протокал, хоршооны хуулийн этгээдийн лавлагаа, хамтран зээлдэгчийн мэдээлэл дутуу, мөн зээлийн гэрээ алдаатай бичсэн зэрэг зөрчил байна	1					1			
ДҮН		3					3			

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			